



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/52

Чингис хот

Уралдаан шалгаруулах ажлын хэсгийг
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33,5, аймгийн Засаг даргын 2021 оны А/238 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Төрийн архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд зарласан уралдааныг шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Мөнгөнцэцэг	Аймгийн Архивын тасгийн дарга
Гишүүдэд:	Б.Оюунтуяа	Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч
	Ц.Гэрэлтуяа	Архивын тасгийн архивч
	Ц.Мягмар-Ариунаа	АЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч
	Э.Заяасайхан	Цахимжуулалт хариуцсан ажилтан

2. Уралдаанд ирүүлсэн данс, түүхчилсэн лавлах болон холбогдох баримтыг заавар журмын дагуу үнэлж, дүгнэн шалгаруулалтыг зохион байгуулж, хурлын тэмдэглэл үйлдэн, дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч бөгөөд Архивын тасгийн дарга (Б.Мөнгөнцэцэг)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР